



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 2/361

Хэрлэн сум

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх  
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Шадар сайдын 2023 оны "Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж", Улсын Онцгой комиссын 2023 оны "Гамшгийн эрсдэлийн бууруулах, урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай" 03 албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахад 23,839,400 (хорин гурван сая найман зуун гучин есөн мянга дөрвөн зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Ард иргэдэд үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг сурталчилах, зөвлөмж, санамж тараах материалыг бэлтгэн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

АВАРГА ТОСОН, ГҮРМИЙН НУУРАНД ЭРГҮҮЛ ХИЙХ ШАТАХУУНЫ ТООЦОО



Аймгийн Засаг даргын  
2023 оны 06 дугаар сарын 26-ны  
дугаар захирамжийн хавсралт

д/д	Хаана	Хугацаа	Эргүүл хийх техник	Тоо ширхэг	Шатахууны зарцуулалт	Явах км	Явах маршрут, хугацаа	Ажлын чиглэл	Шаардлагатай шатахуун		Үнэ
									1 өдөр /удаа/	Нийт	
1	Баян-Овоо сумын Гүрмийн нуур	07-р сарын 01-ээс, 09-р сарын 15 хүртэл. Өдөр бүр 10:00-22:00	Фургон	1	1 км /0.18/	350	Чингис хот, Баян-Овоо сум, Гүрмийн нуур, Баян-Овоо сум Чингис хот	Моторт завь зөөвөргөх, /дотор үйлчилгээнд/	1 /удаа/ 63л	5 /удаа/ 315л	793,800
2		Цагийн хооронд /12цаг/	Моторт завь	1	1 цагт, 8,5л	3 цаг	Усны эргүүл хийх		25.5л	1.963.5	4.948.020
3			Цахилгаан мотор	1	1 цагт, 1л	3 цаг	Гэрэл гаргах, станц хэрэгсэл цэнэглэх		3л	231л	582,120
4	Нийт				77 хоног				91,5л	2,509,5	6,323,940

ХЭРЛЭН, ОНОН ГОЛЫН ДАГУУ УСНЫ ЭРГҮҮЛ ХИЙХ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хаанаа	Хугацаа	Эргүүл хийх техник	Тоо ширхэг	Шатахууны зарцуулалт	Явах км, /хугацаа /	Явах маршрут,	Ажлын чиглэл	Шаардлагатай шатахуун / 1 өдөр /		Үнэ
									1 өдөр /удаа/	Нийт	
1	Хэрлэн гол	06-р сарын 15-аас, 09-р сарын 15 хүртэл. Өдөр бүр 10:00-22:00 цагийн хооронд /12цаг/	Фургон	1	1 км /0.18/	40	Хэрлэн голын гүүрнээс 2 тийш	Моторт завь зөөвөрлөх, усны эргүүл хийх.	7,2л	670л	1,688,400
									6л	558л	1,406,160
									34	3.162	7.968.240
2			Кавдрацкик ол	1	1 км /0.15/	40		Эргүүл хийх	47,2	4390л	11.062.800
3			Моторт завь	1	1 цагт, 8,5л	20 км, /4 цаг /					
4	Нийт				93 хоног						



Зардлын тооцоо

д/д	Нэр төрөл	Хэмжээ /см/	Эх бэлтгэл	Тоо /ширхэг/	Нэгж дүн /төгрөг /	Нийт дүн /төгрөг/
1	Багц мөссөж	-	-	1000	500	500,000 төгрөг
2	Усны осол гарч болзошгүй газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг шинээр байршуулах	100*100	-	19	26500	503,500 төгрөг
3	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх тараах материал хэвлүүлэх	A4	200.000	7000	750	5.450.000
Нийт						6.453.500